



Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг судалсан үр дүн

Батмөнхийн Энхбаяр 
Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Энхбаяр, Б. (2024). Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг судалсан үр дүн. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.6>

Study Results of Thinking Development in Adolescence

Enkhbayar Batmunkh 
Mongolian National Institute for Educational Research

To cite this article:

Enkhbayar, B. (2024). Study Results of Thinking Development in Adolscene. *Mongolian Journal of Educational Research*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.6>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг судалсан үр дүн

Батмөнхийн Энхбаяр

Өгүүллийн мэдээлэл

Өгүүллийн түүх:

Хүлээн авсан: 2024.10.25

Засаж сайжруулсан: 2024.12.19

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2024.12.23

Түлхүүр үг:

Өсвөр насны хүүхэд, сэтгэхүйн талаарх онолууд, хийсвэр сэтгэхүй, утгачлан тогтоох чадвар, сэтгэхүйн ангилах, нэгтгэн дүгнэх чадвар, үгийн утга тайлбарлах чадвар

ХУРААНГУЙ

БСҮХ-ийн судалгааны баг монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааг БШУЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санхүүжилтээр 2014-2017, 2019-2021 онуудад хийж гүйцэтгэсэн байна. Тухайн судалгааны зорилго нь 3-17 насны хүүхдийн цогц хөгжлийн онцлог тогтоох, нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх байлаа.

Энэ удаад суурь, бүрэн дунд боловсролын түвшний хүүхдийн сэтгэхүйн гол шинж болох юмсын үндсэн шинжийг нь зорилготойгоор танин мэдэх чадвар болон ерөнхийлөн дүгнэх чадварыг судалсан судалгааны үр дүнг онол арга зүйн талаас тайлбарлан дэлгэрэнгүй танилцуулахыг зорьж байна. Судалгааны үндсэн арга бол танин мэдэхүйн тест сорил бөгөөд үр дүнг боловсруулахдаа тоон болон чанарын анализыг хэрэглэсэн.

Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 олон улсын лицензээр хамгаалагдсан болно



Холбоо барих зохиогч:

Батмөнхийн Энхбаяр

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Email: enkhbayar@mier.mn

Study Results of Thinking Development in Adolescence

Enkhbayar Batmunkh

Article information

Article history:

Received: Oct 25, 2024

Revised: Dec 19, 2024

Accepted: Dec 23, 2024

Keywords:

adolescence, cognitive theories of thinking, abstract thinking, verbal memory, classification operation of thinking, generalization of thinking, concept defining.

ABSTRACT

In 2019-2021, The Mongolian national institute for educational research has performed research "Development of Mongolian children aged 6-17 years". The purpose of the research was to define characters of physical, social and cognitive development of Mongolian children.

The aim of this article is to introduce survey result of generalization thinking on children aged 11-17 years.

Research methods for children development are psychological cognitive tests. According to research finding, Most adolescence who are 11-17 years old able to think in realistic way commonly. The adolescence thinking demonstrates that has classification operation than generalization. Specifically, in the classification operation, they likely classify things according to external appearance and characteristics. Specially, study results shown that the adolescences' ability to explain words in core meaning is no good. This result may be related to the adolescences' poor focal attention. Furthermore, the study results shown that adolescence thinking and verbal memory has correlative connection. Therefore, teachers and parents supporting for verbal memory is one way of abstract thinking development.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Batmunkh Enkhbayar

Mongolian National Institute for Educational Research

Email: enkhbayar@mier.mn

УДИРТГАЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын цөм нь хүний хөгжил гэж үзсэн байдаг. Хүний хөгжлийг бид насан туршийн хөгжил гэж үздэг хэдий ч хөгжлийн эрчимтэй үе нь хүүхэд залуу нас, ялангуяа 11-17 өсвөр нас юм. Хүний хөгжлийг хурдасгах, сайжруулахын тулд судалгаанд суурилсан хүний хөгжлийн бодлогыг бий болгох нь үр дүнтэй. Ийм ч учраас дэлхийн улс орнууд хүүхэд залуучуудын хөгжлийн онцлогийг судалж, шалгуур үзүүлэлт боловсруулдаг жишиг байна. Өнөөдөр өв тэгш хөгжилтэй иргэн хүнийг төлөвшүүлэхийн тулд бага залуу наснаас нь эхлэн бие бялдар, сэтгэцийн хөгжлийг, ялангуяа оюун ухаан сэтгэхүйн хөгжлийг судлан тодорхойлж түүнд нийцсэн агуулга, арга зүйгээр сургалт хөгжлийн үйл ажиллагааг явуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Өсвөр нас нь хүүхэд наснаас насанд хүрэгч болох шилжилтийн үе юм. Ойролцоогоор 11-16 хүртэлх насыг өсвөр насанд хамааруулж үздэг. Оросын сэтгэл зүйч Л.И.Божович өсвөр насыг 12-15, 15-17 гэж 2 хувааж үзсэн байдаг (Л. И. Божович, 1995). Өсвөр нас нь өөрийгөө тодорхойлох олох үе юм. Сургуулийн дунд, ахлах насанд бие хүний хөгжлийн хувьд өөрийгөө том болсон мэтээр мэдрэх мэдрэмж бий болж, танин мэдэхүйн үйл ажиллагаа нь илүү хийсвэр, учир шалтгаанд үндэслэгдэж өмнөх настай харьцуулахад нарийн түвшний зорилтыг шийдвэрлэх чадвартай болно. Өсвөр насанд хүүхдийн танин мэдэхүйн хөгжил нь нийгэмшлийн хөгжлөөсөө түрүүлж байдаг.

Бага ангиас дунд анги, цаашилбал ахлах ангид ороход хүүхдийн хүрээлэн буй орчинтойгоо ялангуяа хүмүүстэй харилцах, ажил хэрэгт хандах хандлага нь илэрхий өөрчлөгддөг. Тэд урьд нь зугаацах баясах, амрах гэх мэтэд илүү их хугацааг зарцуулдаг байсан бол өсвөр насанд сурч хөгжих үйл ажиллагаанд цагийг өнгөрөөх нь нэмэгдэж өөрийн чадвараа бусдад харуулахыг эрмэлздэг. Мөн хүүхдийн ухамсар ялангуяа өөрийн ухамсар эрчимтэй хөгжинө. Өөрийн тухай, бусад хүмүүс, юмс үзэгдлийн талаарх ухагдахуун төсөөлөл нь илэрхий өргөжсөн нь ажиглагдана. Тухайн насны хамгийн гол онцлог нь идэвхтэйгээр бие даан сэтгэх чадвар юм. Өсвөр насныхан аль хэдийн учир шалтгаан зүй тогтолд нь юмсыг сэтгэх, эргэцүүлэн бодох чадвартай болсон байна. Ахлах ангийн хүүхдүүд нас зүйн сэтгэл судлалын үүднээс салангид зүйлсээс ерөнхий дүгнэлт гаргах, ерөнхийгөөс нэгж дүгнэлт гаргах чадвартай болсон байна гэж үздэг. Өсвөр насныхны нэг гол чадвар нь таамаглал дэвшүүлэх чадвар хэмээн үздэг.

Энэ үед оюун ухааны идэвхтэй үйл ажиллагаа сайжрах ба зарим тохиолдолд оюуны чадвараа батлан харуулахыг эрмэлзэх хандлага нь тухайн насныхны гол онцлог байдаг. Оюуны үйл ажиллагаа идэвхжиж байгаагийн илрэл нь нарийн төвөгтэй зорилтуудыг шийдвэрлэх нь өмнөх настай харьцуулахад илэрхий ажиглагддаг. Тэдний танин мэдэх сонирхол нь өргөн хүрээтэй болж хичээл сурлагын агуулгаас гадна олон зүйлийг сонирхох, мэдлэгийг бие даан эзэмших чадвар нэмэгдэнэ. Мөн энэ насанд танин мэдэхүйн нэг чухал чадвар нь таамаглал дэвшүүлэх болон оюун дүгнэлт гаргах юм.

Боловсрол эзэмших явцад хүүхэд шинжлэх ухааны ухагдахууныг системтэй эзэмшин бодит нөхцөл байдлыг шалтгаан-үр дагаврын харьцаанд нь ойлгох чадвартай болно. Хүүхдийн нас нэмэгдэхийн хэрээр өмнөө тодорхой нарийн зорилго, зорилтуудыг дэвшүүлэн тавьж түүндээ хүрэхийн төлөө оюун ухаанаа дайчлан ажилладаг байна. Хүүхэд юмсыг задлан шинжилж, харьцаа холбоонд ерөнхийлөн нэгтгэх, учир шалтгааныг нь үндэслэлтэйгээр тайлбарлах чадвартай болдог.

Ж.Пиаже өсвөр нас нь хийсвэр сэтгэхүйн хөгжлийн үе бөгөөд хүүхэд үзэгдэл юмсын мөн чанарын талаар таамаглал дэвшүүлэх чадвартай болсон байна гэж үздэг (Martha Lally and Suzanne Valentine-French, 2019). Харин Оросын сэтгэл зүйч Л.С. Выготский тухайн насны хүүхдүүдийн сэтгэхүйн хөгжлийн хамгийн гол онцлогийг ухагдахуун төлөвших үе гэж үзсэн байна. Ийнхүү тэд ухагдахуунаар илэрч буй үзэгдэл юмсыг дотоод, гол шинжээр нь тодорхой бүлэгт нэгтгэх ангилал зүйн чадвартай болно. Энэ нь тэдний сурах үйл ажиллагаандаа амжилт гаргахын үндэс ажээ.

Мөн сургуулийн хүүхдийн сэтгэхүйн үйлдэл (задлан шинжлэх, нэгтгэх, харьцуулах, хийсвэрлэх, ерөнхийлөн дүгнэх, тодорхойлох, ангилах, системчлэх), тэрчлэн сэтгэхүйн хэлбэр болох бодит үйлдлийн, бодит дүрслэлийн ба хийсвэр сэтгэхүйг судлаад сургалтын явцад эдгээрт чанарын өөрчлөлт явагддагийг илрүүлсэн ба энд сургалтын түвшний агуулга нөлөөлдгийг илрүүлжээ.

Сургалт нь хүүхдийн мэдлэгийг ухамсартайгаар эзэмших, мэдлэгт дурлах хүсэл эрмэлзлийг бий болгоход чухал үүрэгтэйг онцолсон (Шардаков, 1963).

Ийм учраас монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлог, ялангуяа тэдний сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судалж, түүнийг харгалзсан бодлого боловсруулж, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээр боловсролын чанарыг сайжруулж иргэн хүний амьдралын чанарыг дээшлүүлэх боломж бүрдэнэ гэсэн үүднээс БШУЯ, БСҮХ нь цөм технологийн судалгааг хэрэгжүүлсэн болно. Бид энэ удаа 2 дахь шатны судалгааны үр дүнгээс танилцуулж байна.

СУДАЛГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС

Хүний сэтгэхүйн процесс буюу сэтгэн бодох үйл ажиллагаа нь тодорхой үйлдлүүдээр хийгддэг ба үүнд задлан шинжлэх, нэгтгэх, ангилах, ерөнхийлөн дүгнэх, хийсвэрлэх, тодруулах, тодорхойлох/тайлбарлах гэсэн үйлдлүүд багтдаг (С.Л.Рубинштейн, 2002).

Сэтгэхүйн үйл явцыг тайлбарласан онолуудыг тоймлон авч үзэхэд, танин мэдэхүйн үйл явц талаасаа юмсыг хүртэж ойлгох, мэдлэг ойлголт, танин мэдэх хүсэл эрмэлзлэл, идэвхтэй сурах үйл явц зэргийг сэтгэхүйн суурь гэж үздэг. Тухайлбал, ХХ зууны эхэн үед Германд үүссэн Гешталт үзэл баримтлалаар, танин мэдэхүйн үйл явц, үүн дотроо сэтгэхүйн үйл явц нь бүхэл бүтэн шинжтэй бөгөөд юмсыг учир шалтгаанд нь сэтгэн бодох, шийдвэр гаргах нь танин мэдэхүйн процесс талаасаа зөвхөн сэтгэхүйн үйл явц бус, бусад процесс болох хүртэхүй, ой тогтоолт, зохион бодохуй тэрчлэн туршлага мэдлэгтэй салшгүй уялдаатай нэгдмэл үйл явц болохыг онцолсон байдаг (Glaser, 1980; 1984). Өөрөөр хэлбэл, шийдвэрлэх гэж буй зорилтоо эхлээд хүн сайтар ойлгох/хүртэх, мөн юмс үзэгдлийн талаар өмнө эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага нь сэтгэхүйн үйл явцын “фон” буюу дэвсгэр болж хийгдэж байгаа үйлдэл/шийдвэрлэж буй зорилт нь “дүрс”-ийн үүргийг гүйцэтгэдэг байна. Тухайн зорилтыг амжилттай шийдвэрлэснээр энэ нь мөн мэдлэг, туршлага өгөх буюу үүссэн дүрс “фон” болж хувирч дахин шинэ үйлдэл/дүрс бий болох тасралтгүй үйл явцаар хүний танин мэдэхүй хөгждөг гэж гешталт сэтгэл судлаачид үздэг (Холодная, 2002). Мэдлэг, чадвар, туршлагын нэг хэлбэр нь хэл ярианы хөгжил, ухагдахууны төлөвшил юм. Ийнхүү үгийн нөөц мэдлэг сайтай байх нь сэтгэхүйн үйлдлийн суурь болж өгнө. Ийм ч учраас хэл яриа нь танин мэдэхүйн хэрэгсэл, цаашилбал хэл яриа ба сэтгэхүйн процесс нь харилцан хамааралтай хөгждөг.

Гэтэл Швейцарийн сэтгэл зүйч Ж.Пиажегийн (1969) үзэл баримтлалаар хүний танин мэдэхүйн үйл явц нь хүрээлэн буй орчиндоо дасан зохицох, харилцан үйлчлэлцэж оршин амьдрах төрөлхийн оршихуйн арга зам бөгөөд хүрээлэн буй орчинтойгоо харилцах арга нь төрөхөөс эхлээд насанд хүрэх хүртэл биологийн мөн чанараараа ялгаатай гэж үзсэнээрээ генетик үзэл баримтлал хэмээн нэрлэгддэг. Хэдийгээр тухайн үзэл баримтлал нь хүний танин мэдэхүйн үйл явцыг хэтэрхий хөдөлшгүй хатуу загвараар тайлбарладаг хэмээн шүүмжлэгддэг ч танин мэдэхүйн үйл явц ялангуяа сэтгэхүйн мөн чанарыг нас зүйн үүднээс тайлбарласан үнэ цэнтэй онол юм. Энэхүү үзэл баримтлалаар сэтгэхүйн үйл явц нь хүрээлэн буй орчинтойгоо идэвхтэй харилцсанаар шинэ туршлага хуримтлуулах тасралтгүй процесс аж. Нөгөөтэйгүүр насны нэг үе шатнаас нөгөө үе шатанд шилжихэд хүрээлэн буй орчинтойгоо харилцах арга хэрэгсэл нь улам нарийсаж, сүүлдээ хэл яриа нь танин мэдэхүйд гол үүрэг гүйцэтгэх болсноор хийсвэрлэн юмсыг ойлгох чадвар сайжран сэтгэхүйн үйл явц нь чанарын шинэ шатанд шилждэгийг онцолсон байдаг. Мөн Ж.Пиаже өөрийн үзэл баримтлалаараа сэтгэхүйн үйл явц нь салангид нэг процесс биш сэрэл мэдрэмж, хүртэхүй, төсөөлөл, хэл ярианы хөгжилтэй холбоотой нэгдмэл үйл явц гэж үзсэн. Гешталт үзэл баримтлалаас ялгаатай нь нэгдүгээрт, насны үечлэлтэй сэтгэхүйн үйл явцыг холбож тайлбарласан, хоёрдугаарт, сэтгэхүй ба хөдөлгөөн хоёрын хоорондын холбоог дэвшүүлэн тавьсан, өөрөөр хэлбэл хүний хөдөлгөөн нь уураг тархи/сэтгэхүйн үйл ажиллагааны үр дүн гэж тайлбарласан, гуравдугаарт, сэтгэхүйн хийсвэрлэлийн түвшнийг гүнзгий авч үзсэн, дөрөвдүгээрт, сэтгэхүйн үйлдлүүд төлөвших дарааллыг нарийн тайлбарласан, дараагийн нэг чухал зүйл бол сэтгэхүй хөгжихийн хэрээр дотоод хэл яриа, хүний үйлдэл илүү товч тодорхой болдгийг дэвшүүлсэн нь генетик үзэл баримтлалын ач холбогдлыг өндөрсгөдөг. Хүний үйлдэлд бодол санаагаа илэрхийлэх, оюуны үйлдэл хийх, мөн гадна тодорхой ажиглагдах үйлдлүүд ч хамаарагдаж болно.

Ж. Пиаже хүүхэд хүрээлэн буй орчиндоо дасан зохицох сэтгэхүйн үйл явцын арга замыг ассимиляци, аккомодаци гэж 2 түвшинд хувааж үзсэн ба ассимиляци нь хүүхэд нэгэнт эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагаараа хүрээлэн буй орчны юмс, үзэгдэлтэй харилцахыг хэлдэг бол

аккоммодаци нь орчны нөхцөл байдал, үүсээд буй асуудал, шаардлагатай уялдан шинээр мэдлэг, чадвар, туршлагыг бий болгосоор орчны юмс үзэгдэлтэй харилцах чадварыг илэрхийлдэг (Ж.Пиаже, 1969; Р.С.Немов, 1995). Хүн зөвхөн “Би” буюу өөрийгөө цөмд тавьж зөвхөн өөрийн зүгээс асуудал, юмсад хандаж, бусдын зүгээс хандах чадвар сул байх, тэрчлэн хүчин чармайлт тавихгүйгээр өөрийнхөөрөө юмсыг үнэлж шинэлэг байдлаар хандахгүй зэрэг нь бүгд л ассимиляцийн илрэл бол хүчин чармайлт тавьж бүтээлчээр асуудлыг шийдэх, юмсыг учир шалтгаанд нь сэтгэн бодож, өргөн хүрээнд бүтээлчээр шийдэж буй нь аккоммодацийн шинж. Ийнхүү аккоммодаци нь сэтгэхүйн хийсвэр шинжийг илэрхийлж байгаа бол ассимиляци сэтгэхүйн бодит шинжийг илтгэдэг байна. Сэтгэхүйн хөгжлийн нэг чиглэл нь ассимиляциас аккоммодацид шилжих шилжилт юм.

Оросын сэтгэл зүйч Л.С.Выготский хүүхдийн сэтгэхүйн хөгжилд хэл яриа, хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцаа, зорилго чиглэлтэй сургалт хөгжлийн үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй гэж үзсэн (Martha Lally and Suzanne Valentine-French, 2019). Дээр дурдсан генетик үзэл баримтлалд, хүүхдийн танин мэдэхүйн хөгжил хатуу тогтсон дарааллаар явагддаг гэдэгт тэрээр шүүмжлэлтэй хандсан. Мөн хүний сэтгэхүйн хөгжилд төрөлхийн биологийн хүчин зүйл гэхээсээ илүү сургалт хөгжлийн үйл ажиллагаа шийдвэрлэх нөлөөтэй ба хүүхэд хэл яриаг эзэмшиж байгаа нь сэтгэхүйн хөгжлийн томоохон дэвшил болохыг онцолдог.

Танин мэдэхүйн чиг хандлагынхан хүний танин мэдэхүй-сэтгэхүйн хөгжилд зорилго чиглэлтэй сургалт хөгжлийн үйл ажиллагаа ихээхэн үүрэгтэй гэж үздэг. Тухайн үзэл баримтлалын гол цөм нь хүний сэтгэхүй бодит энгийнээс хийсвэр нарийн шинж рүү чиглэн хөгждөг гэсэн нь Ж.Пиаже, Л.Выготскийн үзэл баримтлалтай төстэй юм. Тухайн үзэл баримтлалаар үзэгдэл юмсыг танин мэдэх үйл явц нь сэтгэхүйн задлан шинжлэх, ангилах, харьцуулах, нэгтгэх үйлдлийн тусламжтайгаар явагддаг байна. Өөрөөр хэлбэл, задлан шинжлэх-нэгтгэх сэтгэхүйн үйлдэл нь юмсыг танин мэдэх гол арга зам болохыг онцолсон байдаг. Ийнхүү задлан шинжлэх нэгтгэх үйлдэл нь хүртэхүй, ой тогтоолт, зорилго чиглэлтэй сэтгэхүйн үйл явц, мэдлэг туршлага гэх мэт өргөн хүрээний танин мэдэхүйн үйл явцыг агуулдаг ажээ (Дж. Брунер, 1962).

Танин мэдэхүйн сэтгэл судлалаар сэтгэхүйн бүхий л үйл нь задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх үйлдлийн үндсэн дээр явагддаг. Энэ нь дээд мэдрэлийн үйл ажиллагааны гол механизм юм.

С. Л. Рубинштейн (1946) сэтгэхүй нь шууд бус шинжтэй тусгал бөгөөд задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх үйлдэл хэмээн цохон тэмдэглэсэн (С.Л.Рубинштейн, 1989).

Ерөнхийлөн дүгнэх үйлдэл-Энэ нь сэтгэхүйн хамгийн чухал үйлдэл бөгөөд 2 түвшинд хийгддэг. Нэгдүгээрт энгийн түвшинд хийгдэнэ. Гадаад илэрхий шинжийнх нь ижил төстэй байдалд тулгуурлан ерөнхийлөн дүгнэдэг. Үүнийг эмпирик нэгтгэн дүгнэлт гэнэ. Харин танин мэдэхүйн жинхэнэ мөн чанарыг илэрхийлдэг нь 2 дахь түвшний ерөнхийлөн дүгнэлт ба юмс үзэгдлийн хамгийн гол шинжид нь тулгуурлан ерөнхийлөн дүгнэх үйлдэл юм. Үүнийг онолын нэгтгэн дүгнэлт гэж нэрлэдэг.

Ухагдахууны ерөнхийлөн дүгнэлт нь бодит нөхцөл байдал үзэгдэл юмсын талаарх дүр төсөөллийг ухагдахууны хэлбэрээр хийсвэрлэн сэтгэхийг хэлнэ. Ухагдахууны тусгалын сэтгэл зүйн механизм нь ерөнхийлөн дүгнэлтийн түвшин юм. Үүний цаана гол шинжийг гол бусаас ялгаж байгаа процесс байдаг.

Утгын хувьд хамгийн гол шинжийг илрүүлэх үндсэн нөхцөл нь хүн өөрийн байр сууринаас хандахгүйгээр харин нийтлэг шинж, утгын тогтвортой дотоод мөн чанар болон өөр бусад юмс үзэгдэлтэй холбогдох холбоо хамаарлыг нь таних нь гол суурь механизм юм (Холодная, 2002).

Сэтгэхүй нь янз бүрийн арга замаар илэрч болно. Үүнд хэл ярианы шинж, тоон илэрхийлэл, дүрс тэмдэгтийн илэрхийлэл гэх мэт байна. Жишээ нь, оюун ухаан болон сэтгэхүйг судлах тестийн бүтцэд өгөгдсөн үгийн ерөнхий нийтлэг шинжийг олох, тооны зүй тогтлыг олж тоог үргэлжлүүлэх гэх мэт даалгавар байдаг. Эдгээр даалгаврын аль аль нь хүний сэтгэн бодох чадварыг илрүүлэхэд чиглэж байна. Нэгнийх нь агуулга нь хэл ярианы шинжтэй байхад нөгөө нь тоон шинжийг агуулж байна. Иймд хэл ярианы сэтгэхүй, математик буюу тооцооллын сэтгэхүй, орон зай дүрслэлийн сэтгэхүй гэх мэтээр ангилдаг. Үүний гол шалгуур нь юмс үзэгдлийн төлөөллийн хэлбэр юм. Хүн юмсын зүй тогтлыг олох нь янз бүрийн хувилбартай байж болно. Орон зай дүрслэлийн шинжтэй

даалгаврыг биелүүлэх тохиолдолд орон зайн дүрс тэмдэгтүүд нь гол хэрэглэгдэхүүн болно. Жишээлбэл, биетийн багтаамжийг тооцох нь энэ төрлийн сэтгэхүйн хэлбэр болно. Энэ нь хэл ярианы ч шинжийг давхар агуулна.

Сэтгэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт нь асуудлыг шийдвэрлэхдээ мэдлэгийн далайцтай хүрээнд авч үзэх, үзэгдэл юмсын дотоод мөн чанар зүй тогтлыг задлан шинжлэх, харьцуулах чадвар, бүтэц бүрэлдэхүүний уялдаа холбоо, зүй тогтолд нь нэгтгэн ерөнхийлсөн байдал, ухагдахууны талаарх ойлголт, үгийн олон утгыг мэддэг байх зэрэг юм. Ялангуяа хийсвэр, салаа/ижил утгатай ухагдахууны эзэмшилт гол шалгуур болдог.

Иймд дунд, ахлах ангийн сургалтын үйл явц нь мэдлэгийн агуулгыг дамжуулах биш харин мэдлэг бүтээх сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэх нь чухал юм. Ялангуяа, ухагдахуунд задлан шинжилгээ хийх, түүнийг гол шинжээр нь системчлэх, ангилах, бүлэглэх, тодорхойлох чадварыг бий болгох арга зүйн технологи ач холбогдолтой.

Танин мэдэхүйн хөгжлийн сэтгэл судлалд хүний танин мэдэхүйн хөгжил өндөр түвшинд хүрснээр юмсыг учир шалтгаан зүй тогтолд нь сэтгэх, ухааран ойлгох, ерөнхийлөн дүгнэх шинж давамгайлна гэж үздэгийг судалгааны онолын үндэс болголоо (Norman A. Sprinthall Richard C. Sprinthall Sharon N. Oja, 1994).

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн онцлогийг манай эрдэмтэн судлаачид оюун ухааны сонгодог тестүүдийг нутагшуулан хэрэглэх үүн дотроо Векслерийн оюун ухааны сорилоор судлан хэл ярианы ба хэл ярианы бус сэтгэхүйг судалсан нь нийтлэг байна. Судалгааны үр дүнд хэл ярианы сэтгэхүйн хөгжил нь хэл ярианы бус сэтгэхүйн хөгжлөөс өндөр буюу ухагдахуунт сэтгэлгээ, бие даан сэтгэх, эргэцүүлэн бодох чадвар, үгийн утгыг бүрэн илэрхийлэх чадвар сайн хөгжсөн байна гэжээ (О.Мягмар, Б.Туяа. 2015).

Олон улсад өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг нийгэм сэтгэл зүйн чадваруудтай, учир шалтгаанд нь сэтгэх чадварыг насны үе шаттай холбон судлах гэх зэргээр сэтгэхүйн хөгжлийн зүй тогтлыг илрүүлэх судалгаанууд хийгдсэн байна. Тухайлбал, бага, дунд ангийн сурагчдын зорилтыг шийдвэрлэх чадварын ялгаатай байдлыг судлаад өсвөр насанд учир шалтгаанд нь эргэцүүлэн бодож шийдвэрлэх чадвар сайжирдгийг илрүүлжээ. Гэтэл бага ангийн хүүхдүүд “алдаа-оноо” гэсэн зарчмаар санамсаргүй байдлаар үйлдлийг давтан гүйцэтгэх нь түгээмэл байжээ (Sprinthall.N.A, Collins W.A, 1994), (Inhelder B, Piaget J, 1958). Мөн өсвөр насны хүүхдийн хэл ярианы сэтгэхүй нь тэдний харилцааны чадвар, хүлээцтэй зан, өөрийн үнэлгээ зэрэгт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг болохыг илрүүлжээ (Л.А.Ясюкова).

Мөн сэтгэхүйн хөгжлийн түвшнийг сургалтын үйл ажиллагаатай холбон судлах туршлага байдаг. Жишээлбэл, Америкт өсвөр насны хүүхдүүдийг судалсан судалгаагаар, тусгайлсан сургалтад хамрагдсан хүүхдүүдийн сэтгэхүйн хөгжлийн түвшин нь тухайн насны сургалтад хамрагдаагүй хүүхдүүдтэй харьцуулахад сайн байдгийг тогтоожээ (Барнаби Барратт, 1975).

АРГА ЗҮЙ

Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн түвшнийг судлахдаа үгийн утга тайлбарлах, үгийг утгаар нь ангилах сорилыг хэрэглэлээ. Утгын ой тогтоолтыг судлахдаа богино хэмжээний эх уншиж өгөөд хүүхдүүдээр утгыг нь бичүүлэх аргаар судалсан болно.

Сэтгэхүйн хийсвэрлэлийн түвшнийг үнэлэх үүднээс даалгаврууд нь бодит ахуйн шинжтэй, хийсвэр утгатай, салаа/ижил утгатай үг, тэмдэг нэр гэсэн үгийг нийтлэг шинжээр нь ангилах, мөн бодит ахуйн, хийсвэр, салаа/ижил утга бүхий үгсийн утгыг тайлбарлах/тодорхойлох, тэрчлэн бодит ахуйн болон хийсвэр үгийн утгыг харьцуулан нийтлэг шинжийг нь хэлэх аргуудаас бүрдэнэ. Үр дүнг боловсруулах шалгуур үзүүлэлт нь сэтгэхүйн бодит шинжээс хийсвэр шинж рүү чиглэсэн даалгаврын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт, үгийн эмпирик тодорхойлолт ба мөн чанарын тодохойлолтын дундаж үзүүлэлтийг авч үзлээ.

Судалгааны үр дүнг боловсруулахдаа өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх Кронбах альфа коэффициент, фактор анализын хүчин зүйлийн шинжилгээг хэрэглэлээ.

Сэтгэхүйн хөгжлийн түвшнийг үнэлэхдээ дескриптив анализ, ANOVA, корреляцийн шинжилгээний арга хэрэглэлээ.

Боловсруулалтад Лайкертийн 5 хэмжээст шкалыг хэрэглэсэн бөгөөд 1-маш сул, 2-сул, 3-дундаж, 4-сайн, 5-маш сайн утга илэрхийлнэ.

Судалгаанд санамсаргүй түүврийн арга зүйгээр хүйсийн тэнцвэртэй байдлыг ханган оролцогчдыг сонгосон. Нийт 11-14 насны 1350, 15-17 насны 990 хүүхэд оролцсон.

ҮР ДҮН

Фактор анализын хүчин зүйлийн шинжилгээгээр даалгавруудын хүчин зүйлийн коэффициентүүд нь 0.677-0.759, 0.653-0.801 байгаа тул даалгавар гүйцэтгэл хоорондоо харилцан хамаарал сайн, сэтгэхүйн харьцуулах, тодорхойлох чадварын даалгаврууд нь нэг багц, сэтгэхүйн ангилах чадварын даалгаврууд нь нэг багц болж, КМО нь 0.830 байгаа нь даалгавруудын дотоод нийцэл болон түүврийн хүрэлцээт байдал хангалттай байгааг харуулж байна. Багцад орсон даалгавруудын найдвартай чанарын үзүүлэлтийг Кронбах альфа коэффициентээр үзэхэд 0.732-0.809 байгаа тул найдвартай байдлыг хангаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Сэтгэхүйн чадварын фактор анализын хүчин зүйлийн шинжилгээ

Сэтгэхүйн үйлдэл	Хийсвэр сэтгэхүйн чадвар	Тохирц байдал	Найдвартай чанар (Кронбах альфа)
Сэтгэхүйн тодорхойлох, харьцуулан дүгнэх үйлдэл	Ухагдахууныг тодорхойлох чадвар (бодит үг)	0.751	0.732
	Ухагдахууныг тодорхойлох чадвар (хийсвэр үг)	0.759	
	Ухагдахууныг тодорхойлох чадвар (салаа утгатай үг)	0.705	
	Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар	0.677	
Сэтгэхүйн ангилах	Ухагдахууныг ангилах (бодит үг)	0.653	0.809
	Ухагдахууныг ангилах (тэмдэг нэр)	0.834	
	Ухагдахууныг ангилах (нэрлэсэн үг)	0.733	
	Ухагдахууныг ангилах (салаа утгатай үг)	0.801	
	Ухагдахууныг ангилах (хийсвэр үг)	0.755	

Сэтгэхүйн чадвар тус бүрийн хувьсагчийг харьцуулж үзэхэд, 11-17 насныхан ухагдахууныг нийтлэг шинжээр нь ангилах чадвар сайн ($M=2.83-4.20$), үүнийг тодруулан үгийн төрөл зүйлээр нь харахад, бодит утгатай ахуйн ухагдахуун/үгсийг нийтлэгээр ангилахдаа сайн ($M=3.96-4.20$), харин хийсвэр, салаа, тэмдэг нэрийг ангилах нь дундаж түвшинд байна ($M=2.93-3.21$).

Сэтгэхүйн тодорхойлох буюу ухагдахуун тайлбарлах чадвар нь ангилах чадвартай харьцуулахад дундаж түвшинд байна. Үүнийг төрөл зүйлээр нь харахад, бодит/ахуйн шинжтэй ба хийсвэр ухагдахуун/үгсийг тайлбарлах нь дундаж түвшинд ($M=2.86-2.95$) бол салаа/ижил утгатай ухагдахуун үгсийг тайлбарлах нь сул түвшинд байна ($M=2.25$). Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар нь дунджаас доогуур түвшинд байв ($M=2.64$).

Бүх хувьсагчийн стандарт хазайлтын утга нь 0.680-аас 1.305 хооронд хэлбэлзэж байгаа нь өгөгдлүүд хэвийн тархсан ба дундаж руугаа илүү төвлөрснийг харуулж байна. Ассиметр болон эксцессийн утгууд нь модулиараа харгалзан 3 болон 8-аас бага бол нормал тархалтын шаардлага хангана гэж үзсэн байдаг (Kline, 2010). Тухайн тархалтын ассиметрийн утга нь 0.002-оос 0.027-ын, эксцессийн утга нь 0.104-өөс 1.052-ын хооронд хэлбэлзэж буй нь нормал тархалтын шаардлагыг хангаж байна (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Сэтгэхүйн чадварын дескриптив шинжилгээ

	Тоо	Дундаж утга (Mean)		Ста.хаз айлт	Skewness.утга		Kurtosis.утга	
	Ста. утга	Ста. утга	Ста. алдаа	Ста. утга	Ста. утга	Ста. алдаа	Ста. утга	Ста. алдаа
Ухагдахууныг тодорхойлох чадвар (бодит үг)	2337	2.86	.021	.992	.002	.051	-.479	.101

Ухагдахууныг тодорхойлох чадвар (хийсвэр үг)	2330	2.95	.024	1.142	-.100	.051	-.740	.101
Ухагдахууныг тодорхойлох чадвар (салаа үг)	2324	2.25	.023	1.088	.605	.051	-.358	.102
Ухагдахууныг ангилах (бодит үг)	2328	4.20	.014	.680	-.612	.051	1.052	.101
Ухагдахууныг ангилах (тэмдэг нэр)	2319	2.83	.024	1.140	-.052	.051	-.619	.102
Ухагдахууныг ангилах (нэрлэсэн үг)	2317	3.96	.023	1.085	-.916	.051	.104	.102
Ухагдахууныг ангилах (салаа үг)	2318	2.93	.027	1.305	-.066	.051	-1.122	.102
Ухагдахууныг ангилах (хийсвэр үг)	2329	3.21	0.24	1.164	-0.210	.051	-0.771	0.101
Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар	2335	2.64	.017	.829	-.316	.051	-.340	.101

Хувьсагчийг хооронд нь харьцуулж үзэхэд, сэтгэхүйн ангилах чадвар нь сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвараас илүү сайн түвшинд байна. Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн зүй тогтлын дагуу эхлээд хүүхдэд сэтгэхүйн ангилах чадвар хөгжиж нэлээд хожуу ерөнхийлөн дүгнэх чадвар хөгждөг гэж үздэгтэй дүйцэх үр дүн харагдлаа. Нөгөө талаас сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар нь хүүхдийн хэл ярианы хөгжилтэй салшгүй холбоотой хөгждөг тул салаа/ижил утгатай үгийг тайлбарлах, үгсийн нийтлэг шинжийг таньж нэгтгэх чадвар нь харьцангуй сул байлаа (Зураг 1).

Зураг 1. Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн чадваруудын түвшин (дундаж үзүүлэлтээр)



Хувьсагчийн үзүүлэлтүүд нь наснаас хамаарсан ач холбогдол бүхий ялгаатай байна ($P < 0.001$).


Хүснэгт 3. Сэтгэхүйн чадварын наснаас хамаарсан ялгаа

Чадвар	Насны үечлэл	Тоо	Дундаж	Ст. хазайлт	Ст. Алдаа	95% итгэлтэй дунджийн завсрын		F- утга	Ач хол. ялгаа (P-утга)
						Доод хязгаар	Дээд хязгаар		
Ухагдахуун тодорхойлох (бодит үг)	11-14	1350	2.65	0.973	0.026	2.60	2.70	147.335	0.000
	15-17	990	3.14	0.952	0.030	3.08	3.20		
	Бүгд	2340	2.86	0.994	0.021	2.82	2.90		
Ухагдахуун тодорхойлох (хийсвэр үг)	11-14	1350	2.67	1.097	0.030	2.61	2.73	200.266	0.000
	15-17	990	3.32	1.109	0.035	3.25	3.39		
	Бүгд	2340	2.94	1.148	0.024	2.90	2.99		
Ухагдахуун тодорхойлох (салаа утгатай үг)	11-14	1350	2.04	1.033	0.028	1.98	2.09	119.701	0.000
	15-17	990	2.52	1.102	0.035	2.46	2.59		
	Бүгд	2340	2.24	1.089	0.023	2.20	2.29		
Ухагдахууныг ангилах (бодит үг)	11-14	1350	4.04	0.716	0.019	4.01	4.08	121.838	0.000
	15-17	990	4.37	0.670	0.021	4.32	4.41		
	Бүгд	2340	4.18	0.715	0.015	4.15	4.21		
Ухагдахууныг ангилах (тэмдэг нэр)	11-14	1350	2.57	1.151	0.031	2.51	2.63	66.101	0.000
	15-17	990	3.13	1.063	0.034	3.07	3.20		
	Бүгд	2340	2.81	1.148	0.024	2.76	2.86		
Ухагдахууныг ангилах (нэрлэсэн үг)	11-14	1350	3.78	1.144	0.031	3.71	3.84	35.327	0.000
	15-17	989	4.15	1.043	0.033	4.09	4.22		
	Бүгд	2339	3.93	1.118	0.023	3.89	3.98		
Ухагдахууныг	11-14	1350	2.59	1.275	0.035	2.52	2.66	119.701	0.000

ангилах (Салаа утгатай үг)	15-17	990	3.35	1.235	0.039	3.27	3.42		
	Бүгд	2340	2.91	1.312	0.027	2.86	2.96		
Ухагдахууныг ангилах (хийсвэр үг)	11-14	1350	3.08	1.191	0.032	3.02	3.15	35.327	0.000
	15-17	990	3.37	1.123	0.036	3.30	3.44		
	Бүгд	2340	3.20	1.171	0.024	3.16	3.25		
	15-17	991	3.28	0.723	0.023	3.23	3.32		
	Бүгд	2341	3.35	0.701	0.014	3.32	3.37		
Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар	11-14	1350	2.45	0.866	0.024	2.40	2.50	169.643	0.000
	15-17	990	2.89	0.707	0.022	2.84	2.93		
	Бүгд	2340	2.64	0.831	0.017	2.60	2.67		

Сэтгэхүйн ангилах чадварын тухайд, 15-17 настай хүүхдүүдийн тэмдэг нэр, салаа/ижил утгатай үг, хийсвэр үгийг нийтлэг утгаар нь ангилах нь дундаж түвшинд, бодит утгатай үгийг ангилах нь сайн түвшинд байхад, 11-14 насанд тэмдэг нэр, салаа/ижил утгатай үгийг ангилах нь дунджаас доогуур түвшинд байна (Зураг 2).


Зураг 2. Сэтгэхүйн ангилах чадвар, насны бүлгээр (дундаж үзүүлэлтээр)




Ухагдахуун тодорхойлох чадварыг үзэхэд 15-17 настай хүүхдүүдийн 32.8 хувь нь бодит утгатай үгийг мөн чанар (үгийн үндсэн утга)-аар, 11-14 настай хүүхдүүдийн 18.8 хувь нь тухайн төрлийн үгсийг мөн чанараар тус тус тодорхойлж чаджээ.

Хийсвэр утгатай үгсийг 15-17 настай хүүхдүүдийн 43.9 хувь нь мөн чанараар нь тодорхойлж байхад 11-14 настай хүүхдүүдийн 23.0 хувь мөн чанараар нь тодорхойлжээ. Гэтэл эмпирик (үгийн илэрхийлж буй зүйлийн үзүүлэх нөлөө, гадаад шинж) тодорхойлолтыг 15-17 настай хүүхдүүдийн 39.6 хувь, 11-14 настай хүүхдүүдийн 47.8 хувь нь өгч чаджээ.

Зураг 3. Сэтгэхүйн тодорхойлох чадвар, 11-14 нас (хувиар)



Зураг 4. Сэтгэхүйн тодорхойлох чадвар, 15-17 нас (хувиар)



Сэтгэхүйн харьцуулах чадварын тухайд, 15-17 настай хүүхдүүд үгийн утгыг харьцуулан ижил төстэй шинжийг нь таньж ерөнхийлөн нэрлэх чадвар нь дундаж түвшинд ($M=2.89$), 11-14 настай хүүхдүүдийнх дунджаас доогуур түвшинд байна ($M=2.45$).

Хүүхдийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйл


Корреляцийн шинжилгээгээр сэтгэхүйн тодорхойлох, харьцуулан нэгтгэн дүгнэх чадвар нь утгын ой тогтоолттой харилцан хамааралтай хөгждөг байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Сэтгэхүйн тодорхойлох, харьцуулан нэгтгэх чадвар ба утгын ой тогтоолтын корреляци шинжилгээ

Сэтгэхүйн чадвар		Ухагдахууныг тодорхойлох чадвар (бодит үг)	Ухагдахууныг тодорхойлох чадвар (хийсвэр үг)	Ухагдахууныг тодорхойлох чадвар (салаа/ижил үг)	Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар	Утгачлан тогтоох чадвар
Ухагдахууныг тодорхойлох чадвар (бодит үг)	Корр.коэфф	1				
	Ст. Ач хол.					
	Нийт тоо					
Ухагдахууныг тодорхойлох чадвар (хийсвэр үг)	Корр.коэфф	0.496**	1			
	Ст. Ач хол.	.000				
	Нийт тоо	2340				
Ухагдахууныг тодорхойлох чадвар (салаа утгатай үг)	Корр.коэфф	0.461**	0.393**	1		
	Ст. Ач хол.	.000	.000			
	Нийт тоо	2340	2340			
Ухагдахууныг ерөнхийлөн дүгнэх чадвар	Корр.коэфф	0.336**	0.425**	0.330**	1	
	Ст. Ач хол.	.000	.000	.000		
	Нийт тоо	2340	2340	2340		
Утгачлан тогтоох чадвар	Корр.коэфф	.259**	.269**	.318**	.309**	1
	Ст. Ач хол.	.000	.000	.000	.000	
	Нийт тоо	2340	2340	2340	2340	

Сэтгэхүйн харьцуулах, тодорхойлох, нэгтгэн дүгнэх чадварыг илэрхийлэх хувьсагчууд нь нийслэл, ба орон нутгийнх эсэх, мөн хүйсээс хамаарсан статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p<0.001$).


Зураг 5. Сэтгэхүйн чадвар, утгын ой тогтоолт ба нийслэл, орон нутгийн ялгаатай байдал (дундаж үзүүлэлтээр)



Зураг 5-д нийслэлийн хүүхдүүдийн хийсвэрлэн сэтгэх, мэдээллийг утгачлан тогтоох чадвар орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад ялгаатай сайн түвшинд байгаа нь харагдаж байна.

Эмэгтэй хүүхдүүдийг эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад үгийн утгыг тайлбарлах, нийтлэг шинжээр нь харьцуулан ангилах, нэгтгэх, утгаар нь мэдээллийг тогтоон сэргээн санах нь ач холбогдолтой ялгаатай буюу сайн түвшинд байна. Эндээс өсвөр насны охидын хэл ярианы чадвар нь хөвгүүдтэй харьцуулахад илүү байх боломжтой юм гэсэн санааг дэвшүүлэхүйц харагдлаа (Зураг6).

Зураг 6. Сэтгэхүйн чадвар, утгын ой тогтоолтын хүйсээс хамаарсан ялгаатай байдал (хувиар)



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хийсвэр сэтгэхүйн илрэл нь юмсыг гол шинж, харилцаа холбоонд нь ерөнхийлөн дүгнэх чадвар бөгөөд энэ нь хүүхдийн хэл ярианы хөгжилтэй салшгүй холбоотой хөгждөг. Иймд өсвөр насанд хүүхэд хийсвэр ухагдахууны эзэмшилт нь нэмэгдэж уг яриагаар дамжуулан юмс үзэгдлийг хийсвэрлэн ойлгох чадвартай болж байгаа нь бүхэлдээ танин мэдэхүйн хөгжлийн дэвшил байдаг. Судалгааны үр дүнгээс харахад, хүүхдүүдэд бодит сэтгэхүйн хэлбэр давамгайлж байгаа тул үүнийг сургалтад харгалзан үзэж оновчтой арга зүйгээр сургалт хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулахаас гадна хүүхдийн хийсвэр сэтгэхүйн хөгжлийг дэмжих арга зүй шаардлагатай байна.

Өөр нэг чухал хүчин зүйл нь хэл ярианы сэтгэхүйн хөгжил нь мэдээллийг утгачлан тогтоох чадвартай харилцан хамааралтай учраас хүүхдүүдийн ойлгож унших чадварыг дэмжих нь сэтгэхүйн хөгжил цаашилбал, танин мэдэхүйн хөгжлийг бүхэлд нь дэмжихүйц үр нөлөөтэйг сургууль, гэр бүлийн орчинд анхаарах цаг болсныг илтгэж байна.

ДҮГНЭЛТ

Өсвөр насны хүүхдүүдийн танин мэдэхүйд бодит сэтгэхүй давамгайлах нь нийтлэг ба сэтгэхүйн хувьд нийтлэг шинжээр нь ангилах ангилал зүйн чадвар давамгай, ингэхдээ гадаад илэрхий шинжээр нь ангилах нь сайн байна. Сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварыг тодорхойлдог сэтгэхүйн тодорхойлох, харьцуулан нийтлэг шинжээр нь нэгтгэх чадвар хожуу хөгждөг дүр зураг харагдлаа. Ялангуяа, үгийг үндсэн утгаар нь тайлбарлах, утгын нийтлэг шинжээр нь нэгтгэх нь сул байна. Эдгээр нь хүүхдүүдийн анхаарлын төвлөрөл сул байгааг давхар илэрхийлж байгаа юм. Хүүхдийн

сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар нь мэдээллийг утгачлан тогтоох чадвартай шууд харилцан хамааралтай тул тухайн чадварыг дэмжих аргаар өсвөр насны хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх боломжтой байна. Сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар гэдэг нь үзэгдэл юмсын харьцангуй тогтвортой шинж чанар, харьцааг тусгасан танин мэдэхүйн процесс гэж үздэг тул тухайн чадварыг сургалтаар хөгжүүлснээр бүхэлдээ хүүхдийн юмс үзэгдлийг хүлээн авах, ойлгох, цаашилбал, асуудалд бодитоор хандах хандлагыг нь дэмжих ач холбогдолтой (Д.Санжжав, С.Энхболд, 2000).

Сэтгэхүйн ангилах, харьцуулах, тодорхойлох чадварууд нь нас нэмэгдэх тусам сайжирдаг байна ($P < 0.001$). Хүүхдүүдийн ухагдахууны эзэмшилтийн тухайд бодит ахуйн шинжтэй үг давамгайл байна. Үгийн нөөц нь салаа утгатай болон тэмдэг нэр, хийсвэр утгатай ухагдахууны эзэмшилтээр нэмэгддэг дүр зураг харагдлаа. Хүүхдүүдийн сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар нь мэдээллийг утгачлан тогтоох чадвартай харилцан хамааралтай хөгждөг байна.

Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжил болон мэдээллийг утгачлан тогтоох чадвар нь хөдөө орон нутаг, хотод амьдарч байгаа эсэх болон хүйсийн хувьд ялгаатай байна. Улаанбаатар хотын хүүхдүүдийн сэтгэхүй болон утгын ой тогтоолт нь статистик ач холбогдлын түвшинд илүү эерэг, мөн охидын сэтгэхүйн болон утгын ой тогтоолт нь хөвгүүдтэй харьцуулахад илүү байна ($p < 0.001$).

Мэдээллийг утгаар нь тогтоох, ойлголтыг ижил төсөөтэй шинжээр нь ангилах, нэгтгэх үйлийг хичээл, сургалтын явцад гүйцэтгүүлэх нь үр дүнтэй нь харагдлаа. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ойлголтыг бодитоор үзүүлж тайлбарлах нь үр дүнтэй ба хийсвэр ойлголтыг зөв ойлгоход багш анхаарах нь зүйтэй.

ТАЛАРХАЛ

Судалгааны мэдээлэл цуглуулах, тайлан боловсруулах, үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажилласан багийнхан болон Хүний хөгжлийн судалгааны сектор, бусад секторын эрдэм шинжилгээний ажилтнууддаа талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- Inhelder B, Piaget J. (1958). *The growth of logical thinking from childhood to adolescence*. New York.
- Kline, R. (2010). *Principles and Practice of Structural Equation Modeling*. New York: the Guilford press.
- Martha Lally and Suzanne Valentine-French. (2019). *Lifespan Development: A Psychological Perspective Second Edition*. San Francisco, California.
- Norman A.Sprinthal Richard C.Sprinthal Sharon N.Oja. (1994). *Educational psychology: A developmental approach -6th ed.*. New York.
- Sprintall. N.A, Collins W.A. (1994). *Adolescent psychology: A developmental view*. New York.
- Ж.Пиаже. (1969). *Избранные психологические произведения*. Москва.
- Р.С.Немов. (1995). *Психология образования*. Москва.
- С.Л.Рубинштейн. (1989). *Основы общей психологии*. Москва.
- С.Л.Рубинштейн. (2002). *Основы общей психологии*. Питер.
- Санжжав Д. Энхболд С. (2000). *Сэтгэл судлалын ухааны тайлбар толь*. Улаанбаатар.
- Холодная, М. (2002). *Психология интеллекта: парадоксы исследования*. Санктпетербург: Питер.
- Шардаков, М. (1963). *Мышление школьника*. Москва.

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Батмөнхийн Энхбаяр



<https://orcid.org/0000-0001-7174-1672>

Байгууллагын нэр: БСҮХ

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 10,
Багшийн хөгжлийн ордон 301 тоот

Улс: Монгол

e-mail: enkhbayar@mier.mn